



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 дугаар сарын 09

Дугаар 09

Улаанбаатар хот

“Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 04 дугаар сарын 09-ний өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Б.Зоригтбаяр хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн талаар Хяналтын зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжийг хэлэлцэж, шийдвэрлэх

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

“Хувьцаа эзэмшигч Б.Зоригтбаярын хүсэлттэй холбоотойгоор Хяналтын зөвлөлөөс 2024 оны 03 сарын 29-ний өдрийн ХЗ/07 дугаар санал, зөвлөмжийг хэлэлцээд дараах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Цогтбаяр)-д даалгав.

1. Хувьцаа эзэмшигчдийг тогтмол мэдээллээр хангах үүднээс компанийн санхүүгийн тайланг улирал тутам гаргаж, улирал дууссанаас хойш 4 дэх долоо хоногийн хамгийн сүүлийн 5 дахь өдрийн 14:00 минутад компанийн албан ёсны цахим хуудсанд байршуулж ажиллах,
2. Компанийн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчийг хэлэлцэж буй асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, компанийн удирдлагаас асуулт бүр дээр хариулт өгөх боломжоор хангаж ажиллах,
3. Б.Зоригтбаяр хувьцаа эзэмшигчээс ирүүлсэн өргөдөлд холбогдох хууль, журмын дагуу хариу хүргүүлэх.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрт тогтмол хяналт тавьж ажиллахыг Аудитын хорооны дарга (Н.Улаанхүү)-д үүрэг болгов” гэжээ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ТОГТОХБАЯР

1524023119